

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2023 оны 06 сарын 09

УБЕГазраас албан бичгээр ирүүлсэн 13 удаагийн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

1-рт. УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар, хэлтсийн даргаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- 2023 оны 01 сарын 25-ны өдрийн дотоод мэйлээр ирсэн 100 гаас дээш настай 5 иргэний бүртгэлийг тулгаж ирүүлнэ үү гэсний дагуу тус аймгийн харьяат 100 настай 2 иргэн, 99 настай 3 иргэний мэдээллийг статистикийн хэлтэс, улсын бүртгэгчидтэй тулган гаргаж хүргүүллээ.
- 2023 оны 01 сарын 11 -ний өдрийн 4/363 тоот албан бичгээр гадаад паспортын талаар авах арга хэмжээний тухай УБЕГазрын ИУБГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу гадаад паспортын бүртгэлийг тухай бүр баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд гадаад паспортын хэвлэгдэн ирж байгаа хугацаа богиносож түргэн шуурхай болсонд иргэд талархаж байгаа.
- УБЕГазрын ИУБГазраас тус аймгийн хэмжээнд нэг хаяган дээр 10-аас дээш иргэн бүртгэлтэй хаягийн жагсаалтыг ирүүллээ. Жагсаалтад 266 хаяг дээр нийт 3314 иргэн бүртгэлтэй байна. Дараах жагсаалтын дагуу мэдээллийн сангаас иргэдийн нэрсийг шалгаж тухайн хаяг дээрээ амьдардаг эсэх хаягийн зөрчилтэй байгаа тохиолдолд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийж зөрчил арилгах талаар сумдын бүртгэгчдэд хугацаатай үүрэг өгч ажиллалаа. Бүртгэлийн цахим системд хаяг зөрүүтэй гэж мэдээлэл өгсөн 7 иргэний бүртгэлийг шалган иргэдтэй холбоо барьж тус бүр мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.
- Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст 3 удаа тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж тайлагнасан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээг улирал бүр Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна
- ГБХЗХГазарт үрчлэгдсэн хүүхдийн судалгааг 1 удаа гаргаж өгсөн.
- Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2023 оны 04 сарын 10-ны өдрийн шуурхай хурлаар тус аймгийн хэмжээнд нийт 1199 гадаад паспорт олгосон бөгөөд хурууны хээгээр бүртгэл хийсэн 708, регистрийн дугаараар бүртгэл хийсэн 491 паспортын захиалгыг авсан. Регистрийн дугаараар гадаад паспортын бүртгэл хийсэн шалтгаан нөхцөлийг олж илтгэх хуудсыг хүргүүлсэн.
- Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 15991 иргэн буюу 49,9 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 14209 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1782 иргэнд гар утасны gsign апплекейшнээр дамжуулан олголоо.
- УБЕГазрын 2023 оны 04 сарын 26 ны өдрийн 3/3791 тоот чиглэлийн дагуу улсын бүртгэгчид иргэний улсын бүртгэлийн зарим лавлагааг ИУБ хөтлөхдөө “албан хэрэгцээнд ” зориулалтаар цаасаар хэвлэхгүй лавлагааг үүсгэсэн тухай түүхийг санд үүсгэн, журнал бүртгэлд тэмдэглэн бүртгэл хөтөлж байна.

Нөхөн сонгуулийн ажлын хүрээнд хийгдсэн ажлууд

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд УБЕГ-аас өгсөн заавар, цахим чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Тус аймгийн Баянжаргалан сумын ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн

ХЭВЛЭГДСЭН СОНГОГЧДЫН ТООН МЭДЭЭ

Тайлан 5

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум дүүргийн нэр	Хэсгийн дугаар	Үндсэн				Түр хасав			Нийт
				Үндсэн	Цагдаагийн албан хаагч, Дотоодын цэргийн анги	Тусгай анги салбарын алба хаагч, ажилтан	Зэвсэгт хүчний цэргийн ангийн алба хаагч, ажилтан	Эрх зүйн чадамжгүй	Хорих анги, эрүүгийн хэрэг, албадан эмчлүүлсэн	Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон	
1	Дундговь	Адаацаг	2-3	314	0	0	0	0	2	2	318
2	Дундговь	Баянжаргалан	3-1	185	0	0	0	0	1	2	188
3	Дундговь	Өлзийт	10-3	221	0	0	0	1	0	1	223
4	Дундговь	Хулд	13-1	311	0	0	0	1	0	2	314
				1,031.00	0.00	0.00	0.00	2.00	3.00	7.00	1,043.00

01 тоот тогтоол “Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийн тов зарлах тухай”, Адаацаг сумын ИТХ-ын 2023 оны 02 сарын 9-ний өдрийн 01 тоот тогтоол “ Нөхөн сонгуулийг товлон зарлах тухай”, Хулд сумын ИТХ-ын 2023 оны 01 сарын 30-ны өдрийн 14/01 тоот тогтоол “ Нөхөн сонгуулийг товлон зарлаж, хэсгийн тоо, нутаг дэвсгэрийн төвийн байршил тогтоох тухай, Өлзийт сумын ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 65 дугаар тогтоол “ Нөхөн сонгуулийн тов зарлах тухай ” тогтоолуудыг хүлээн авч эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүллээ.

- Иргэний улсын ахлах бүртгэгч хэсэг байгуулсан тогтоолыг шивэх эрх авсан ба хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээллийг тогтоолуудтай тулган шалгаж, санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах хаягийн мэдээллийг мэдээллийн санд шивж, баталгаажуулсан. Сонгуулийн эрх бүхий иргэний мэдээллийг давхардалгүй, үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэсэн эсэхийг байнга нягтлан шалгаж ажилласан.
- Аймгийн хэмжээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зогсоож, энэ өдрөөс өмнө шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлж, баталгаажуулаагүй бүртгэл байхгүй буюу бүртгэсэн, алдаатай төлөвтэй бүртгэл байхгүй. 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хөтлөгдсөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж дуусгасан. Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан, дэвтэрт бүртгэсэн, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулаагүй бүртгэл байгаагүй.
- Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн чиглэлийн дагуу тус аймгийн Хулд сумын шувуутай багийн 5 иргэн нэрийн жагсаалтад бүртгэлгүй байна гэх мэдээллийг шалгаж үзэхэд иргэний бүртгэлийн мэдээллийн санд хаягтай боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлгүй байсан Election.gasr.mn программд хулд сумын 1-р баг шувуутай багт дээрх 5 иргэний хаяг нэмэгдэж ороогүйн улмаас сонгогчдын нэрийн жагсаалтад байхгүй байсан тул хаягийг нэмж оруулан шалгаж үзэхэд иргэдийн бүртгэл сонгогчдын нэрийн жагсаалтад орж ирж зөрчилгүй болсон.
- Сонгогчдын нэрийн жагсаалтыг election.gasr.mn хаягаар шалган ажилласан ба сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой гомдол, санал ирээгүй. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /гар хурууны хээ/-д шинээр, 25, 45 насанд сольж, хаяж, гээж, үрэгдүүлсэн шалтгаанаар дахин олгох бүртгэлд бүртгүүлж байгаа иргэдийн бүртгэлийг баталгаажуулахдаа иргэний байнга оршин суух хаягийн мэдээлэл, сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт бүртгэгдсэн эсэхийг тухай бүр нягтлан шалгасан.
- Иргэний улсын бүртгэлийн газраас сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах, хэрхэн яаж хэвлэх, хэдэн хувь хэвлэх, хэрхэн баталгаажуулах талаар өгсөн зөвлөмжийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг

хэвлэх, хүргүүлэх ажлыг зохион байгууллаа. Тус аймгийн Сайнцагаан суман тогны хязгаарлалтыг 17.00 цаг хүртэл хязгаарлаж иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн заасан хугацаанд хэвлэж чадаагүй. Сонгогчдын нэрийн жагсаалтыг 17 цаг 30 минутад хэвлэж дууссан. Хэвлэхэд ямар нэг хүндрэл бэрхшээл учраагүй. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 4 хэсгийн 1043 иргэний жагсаалтыг улсын ахлах бүртгэгч тус бүр 2 хувь хэвлэн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч хяналт тавин хэлтсийн тамга, ахлах бүртгэгчийн тэмдгээр баталгаажуулан дугтуйлж хэсгийн хороодод хуулийн хугацаанд хүргүүлсэн.

- Итгэмжлэгдсэн ажилтны судалгааг 2023 оны 5 сарын 22-ны өдөр гаргаж ИУБГазрын ахлах бүртгэгч Б. Отгонд хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн ажилтай холбоотой 7 ажлын хүрээнд хийгдсэн ажлуудыг тухай бүр илтгэх хуудсаар ch.battsetseg@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн ажилласан.

2-рт Иргэний бүртгэлийн чиглэлээр:

Эхний хагас жилд **5322** иргэнд иргэний гэр бүлийн бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. Тайлант хугацаанд ИГББүртгэлийн сар бүрийн тоон мэдээний нэгтгэлийг 5, инфографик мэдээ 5 удаа гаргаж өгсөн. Тайлант хугацаанд 386 албан бичиг явуулж, 190 албан бичиг хүлээн авснаас 120 хариутай албан бичгийн хүрээнд 396 лавлагааг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Бүртгэлийн ачааллыг тэнцвэржүүлэх бүртгэл бага гарч байгаа сумдын улсын бүртгэгчдийг Сайнцагаан суманд ажлын 5 хоногоор ажиллах хуваарийг баталж хуваарийн дагуу улсын бүртгэгчид бүртгэл хийх, анхан шатны нотлох баримтыг цахимжуулах, үдэж архивлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

2023 оны 05 сарын 31 байдлаар **824** иргэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан бөгөөд шинээр **275** иргэн, 25 насны сунгалтаар **277** иргэн, 45 насны сунгалтаар **286** иргэн бүртгэлд хамрагдсан. Иргэний улсын бүртгэлийн газраас 15 удаагийн ээлжээр 905 иргэний үнэмлэх хүлээн авсан үүнээс 16 насанд хүрч шинээр иргэний үнэмлэх захиалсан 264, хаяж үрэгдүүлсэн болон дахин захиалсан 164, 25 болон 45 насны сунгалтаар 477 иргэний үнэмлэх хэвлэгдэн ирснийг сумдын улсын бүртгэгчдэд хүргүүллээ


E-mongolia.mn цахим үйлчилгээний нэгдсэн системээс иргэний улсын бүртгэлийн 16 төрлийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний 9, улсын бүртгэлийн 13 төрлийн лавлагаа нийт улсын бүртгэлийн 13 төрлийн лавлагаа нийт 38 төрлийн үйлчилгээг авах боломжтой бөгөөд он гарсаар иргэний үнэмлэх хаяж үрэгдүүлсэн 43 иргэн e-mongolia.mn системээр иргэний үнэмлэхээ захиалж авсан байна.

Мөн Дэрэн, Эрдэнэдалай сумдад “Гэрэгэ систем, Сайнцагаан суманд төлбөрийн пос машиныг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлсэн нь үйлчилгээний шат дамжлага бууруулсан, цаг хугацаа зардал хэмнэсэн үйлчилгээ болж байна

Иргэний улсын бүртгэлийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Иргэний үнэмлэхийн зураг засварын программ ашиглах заавар, анхаарах асуудал” сэдэвт цахим сургалтын дагуу Мэдээлэл технологийн газраас **470** иргэний зургыг хүлээн авч, мэдээллийн санд нэг бүрчлэн нягтлан шалгаж, зөрчилгүй тухай илтгэх хуудсыг иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд **341** хүүхэд, гэрлэлтийн бүртгэл **84**, үрчлэлт **5**, гэрлэлт цуцлалтын бүртгэл **17**, эцэг тогтоолтын бүртгэл **8**, ОНӨ бүртгэл **16**, нас барсны бүртгэлд **104** нийт иргэний гэр бүлийн бүртгэлийн **575** бүртгэл, **663** иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд, үндэсний энгийн гадаад паспорт **1104** иргэнд олгож нийт **2342** иргэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэж мэдээллийн санд баталгаажуулсан байна. Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас 343 хүүхдийн регистрийн дугаарыг унагаж төрсний бүртгэлд бүртгэсэн бөгөөд 167 эрэгтэй, 174 эмэгтэй хүүхэд төрсөн байна. Төрсөн эхчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-19 насны 18, 20-24 насны 80, 25-29 насны 92, 30-34 насны 89 эмэгтэй төрсөн нь нийт төрсөн эхчүүдийн 81,3 хувийг эзэлж байна. Батлуулсан гэр бүлтэй 151 эмэгтэй, батлуулаагүй гэр бүлтэй 140 эмэгтэй төрж бүртгэгдсэн байна. Бүрэн дунд боловсролтой 138, дээд боловсролтой 117 эх төрсөн байна. Нийт төрсөн хүүхдийн 58,9 хувь буюу 202 хүүхэд Сайнцагаан суманд төрсний бүртгэлд хамрагдсан байна.

Нийт **2012** лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр **207** лавлагаа хэвлэж олгосноос цагдаагийн байгууллагын хүсэлтээр **95**, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр **108**, Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн хүсэлтээр **3**, лавлагааг тус тус олгосон. Албан хэрэгцээнд **405** лавлагааг улсын бүртгэгчид хэвлэж, иргэний хүсэлтээр **1400** лавлагаа олгосон байна.



Эхний хагас жилд **663** иргэн шилжин ирсний бүртгэлд хамрагдсанаас гадны аймаг хотоос **153** иргэн бүртгэгдсэн. Үүнээс 16-аас дээш насны **102** иргэн, 16-аас доош насны **51** иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдаж, **510** иргэн аймаг дотор буюу сумаас суманд, багаас багт шилжин ирсэн бүртгэл хийлгэсэн байна. Улаанбаатар хотоос 74 иргэн, Төв аймгаас 12, Говьсүмбэр аймгаас 12 иргэн шилжин ирсэн нь нийт шилжин ирсэн бүртгэлийн 64 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд **459** иргэн өөр



аймаг хотод шилжин явснаас 16-аас доош насны **162**, 16-аас дээш насны **297** иргэн өөр аймаг хотод шилжин явсан хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан байна.

Тус хэлтсээр дамжуулан **1104** иргэнд цахим болон үндэсний энгийн гадаад паспорт олгосон бөгөөд **427** иргэнд шинээр, **477** иргэнд дахин олголоо. Дахин гадаад паспорт захиалж байгаа иргэдийн өмнөх паспортыг

мэдээллийн санд тухай бүр хүчингүй болгож байгаа ба 477 иргэний хуучин паспортыг

хүчингүй болгосон байна. 2023 оны 01 дүгээр сараас эхлэн ИУБГ, МТГ-аас хийсэн 3 удаагийн гадаад паспортын программын болон эрх зүйн цахим сургалтад гадаад паспортын бүртгэл хариуцсан бүртгэгч, иргэний улсын ахлах бүртгэгч нар оролцож цахим гадаад паспортын зураг авах, цахим гадаад паспортын захиалга авахад программын сургалтад хамрагдсан. 2023 оны 03 сарын 1-ний өдрөөс олгож эхэлсэн цахим гадаад паспортын эрхийг нэг цэгийн үйлчилгээний 2 иргэний улсын бүртгэгчид нээлгэж **235** иргэнд цахим гадаад паспорт олгосон бөгөөд бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласнаар цахим гадаад паспорттай холбоотой гомдол санал ирээгүй захиалга хэвийн явагдаж байна. ИУБГаараас өгсөн чиглэлийн дагуу гадаад паспортын бүртгэлийг тухай бүр баталгаажуулж байна. Иргэний

улсын бүртгэлийн газраас улсын ахлах бүртгэгчдэд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн эрхийг 2022 оны 11 сард олгож мэдээллийн санд зөрүүтэй алдаатай бүртгэлийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр засварлах боломжийг өгсөн нь цаг хугацаа, шат дамжлагыг бууруулсан шийдвэр байлаа. Иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн үнэн зөв байлгах иргэдийг цахим орчноос бүртгэлийн үйлчилгээ болон лавлагаа мэдээллийг авахад түргэн шуурхай чирэгдэлгүй авах боломжийг хангах зорилгоор иргэний бүртгэлийн санд зөрүүтэй 135 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулж мэдээллийн санд алдаагүй болгож ажилласан. Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг 0-16 насны хүүхдийн төрөлтийн бүртгэлд УБЕГазрын Хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагч Ч. Эрдэнэчимэгийн 2022 оны 03 сарын 03-ны өдрийн 1543 тоот дүгнэлт, 16-аас дээш насны иргэний нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны 02- сарын 03-ны өдрийн 871 тоот дүгнэлтүүдийг тус тус үндэслэн оруулсан.

УБЕГазрын хяналт шалгалтын газраас нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд хяналт орж 18 бүртгэлийн дүгнэлтийн дугаарыг оруулаагүй зөрчлийг арилгуулах тухай улсын байцаагчийн албан шаардлагын дагуу УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Б. Отгоноос зөвлөмж авч 13 бүртгэлийн дүгнэлтийн дугаарыг цахимжуулж, 2 иргэний гэрлэлтийг нөхөн бүртгэлээр мэдээллийн санд оруулж овог нэр, эцэг тогтоолтын 2 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 2788 тоот дүгнэлтийг гаргуулан хувийн хэрэгт цахимжуулан гарсан зөрчлийг бүрэн арилгаж ажиллалаа.

Сургалт, сурталчилгаа:

- ✚ УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас “Иргэний үнэмлэхийн зураг засварын программ ашиглах заавар, анхаарах асуудал”, “Цахим гадаад паспортын программын танилцуулга”, ны “Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх”, “Цахим гадаад паспортын талаар чиглэл өгөх”, “Засвар өөрчлөлтийн бүртгэлийн талаар чиглэл өгөх”, “ НАГ-аас болон тамгын газрын хамтарсан чиглэл өгөх”, “ХШГ болон ИУБГ-ын хамтарсан албан шаардлагын талаар чиглэл хүргүүлэх”, “Д.Дэлгэрсайхан-Аймаг, дүүргийн УБХ-ийн дарга, иргэний ахлах, Нэгдсэн төвүүдийн ахлахуудад чиглэл хүргүүлэх” талаар ахлах бүртгэгч нарт чиглэл өгөх тухай, сумдын улсын бүртгэгч нарт “Иргэний улсын бүртгэлтэй холбоотой асуудал” сэдвээр арга зүйн 11 удаагийн онлайн сургалт, ахлах бүртгэгч нарт зориулсан 1 удаагийн танхимын сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан.
- ✚ Шинэ загварын иргэний үнэмлэх хэвлэгдэн ирж байгаатай холбогдон улсын бүртгэгчдэд мэдээлэл хийж иргэдэд иргэний үнэмлэхийн талаарх мэдээллийг хүргэж ажиллахыг зөвлөлөө.
- ✚ Цахим гадаад паспорт хэвлэгдэж эхлэхтэй холбоотой УБЕГазрын ИУБГаараас явуулсан онлайн сургалтад тус тасгийн 3 бүртгэгч хамрагдсан. Мөн сургалтын системд тавигдсан онлайн хичээлийг судалж байна.

- ✚ Тоон гарын үсгийг эрчимжүүлэх талаар бүртгэгчдэд онлайн сургалт 1 удаа зохион байгуулсан.

Тайлант хугацаанд 15 удаагийн сургалт мэдээллээр 5540 иргэнд бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан байна. Үйл ажиллагаатай холбоотой 16 мэдээ мэдээллийг УБЕГазрын вэйб хуудас, Улсын бүртгэлийн ерөнхий газрын фэйж хуудаснаас Дундговь улсын бүртгэлийн хэлтэс нээлттэй групп, Бүртгэлийн хэлтсийн фэйж хуудсанд шэйр хийж түгээсэн. Дундговь аймгийн засаг дарга Ж. Мөнхбат түүний тамгын газраас 2023 оны 02 сарын 06-12 ны өдрүүдэд Дэрэн, Цагаандалгар, Говьугтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт сумдад зохион байгуулсан “Иргэдээ сонсьё” өдөрлөгийн хүрээнд Иргэний бүртгэлийн чиглэлээр 125 иргэнээс гадаад паспортын захиалга авч, 86 иргэнд тоон гарын үсэг олгож 46 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа



- 2023 оны 5 сарын 10-ны өдөр Дэлгэрхангай суманд зохион байгуулагдсан “ Малчны өдөрлөгт” оролцон 250 иргэнд мэдээлэл хүргэж 48 иргэнд тоон гарын үсэг олголоо.
- 2023 оны 5 сарын 15-23 ны өдрүүдэд Дундговь аймгийн засаг дарга Ж. Мөнхбат “Иргэдээ сонсьё” өдөрлөгийг аймгийн баруун сумд болох Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхановоо, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт сумдад зохион байгуулсан . Өдөрлөгийн хүрээнд Иргэний бүртгэлийн чиглэлээр 78 иргэнээс гадаад паспортын захиалга авч, 102 иргэнд тоон гарын үсэг олгож иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа
- Аймгийн засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн №1 захирамжаар “Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил “болгон зарласан бөгөөд Улсын бүртгэлийн хэлтсээс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой хэлбэрээр сурталчлах зорилгоор “Бүртгэгч багш ” мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж ирсэн. Энэ удаа Сайнцагаан сумын “Мандал” сургуулийн 10,11 дүгээр ангийн 145 сурагч, Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 9



дүгээр ангийн 40 сурагчийг хамруулан зохион байгууллаа. Говьугтаал, Дэрэн сумдын улсын бүртгэгчид сумынхаа ерөнхий боловсролын сургуулийн 65

сурагчдын дунд “Бүртгэгч багш” өдөрлөгийг зохион байгуулсан байна. Мөн өдөрлөгийн үеэр “Алтан хонх” танин мэдэхүйн тэмцээнийг явуулж түрүүлсэн сурагчдыг урамшуулсан байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХААН банкны хамтын ажиллагааны хүрээнд “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян” –г 2023 оны 04 сарын 3-ны өдрөөс 2023 оны 06 сарын 30 хүртэл зарлан тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх, иргэдийн тоон гарын үсгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд ХААН банкин дээр үйлчлүүлж байгаа иргэдэд 4 жи төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсэг олгож ажлыг зохион байгуулсан.
- ИГББүртгэлийн сар бүрийн статистик тоон мэдээгээр инфографик мэдээллийг 5 удаа бэлтгэн мэдээлэл технологийн ажилтанд гаргаж өглөө.
- 2023 оны 01 дүгээр сарын 09-нд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас “Шинэ хуулийн төсөл”, 2023 оны 03 дугаар сарын 03-нд Монгол банкнаас “Цахим залилан”, 2023 оны 04 дүгээр сарын 12-нд ХААН банкнаас “Аяны хүрээнд хамтран ажиллах” сэдэвт сургалтуудад бүх албан хаагчид оролцсон



БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ, ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд иргэн, ЭХЭУБ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 1163 бүртгэлд хяналт шалгалт хийгээд байна. Иргэний улсын бүртгэлийн 38, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 42 бүртгэлд алдаа зөрчил илэрсэн бөгөөд тухай бүр улсын бүртгэгчид зөвлөмж өгч засч ажиллалаа. Тайлант хугацаанд 26 дүгнэлт үйлдсэнээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9, иргэний улсын бүртгэлийн 17 байна.

Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйл. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих буюу 15.24.1, 15.24.2, 15.24.4-т зааснаар иргэд торгууль төлж байгаа бөгөөд олон нийт иргэдэд зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор видео шторк явуулах, facebook хуудсаар мэдээлэл түгээх зэрэг ажлуудыг хийлээ. Мөн түүнчлэн 15 сумдын улсын бүртгэгч нараас тухайн онд 16, 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэх захиалах иргэдийн судалгааг авч, иргэн бүртэй утсаар холбогдож төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор иргэний үнэмлэхийн сунгалтаа хийлгэх ёстойг сануулсан мессеж үйлчилгээ, сануулгыг хүргэж улмаар зөрчлийн тухай хуулиар торгуулах иргэдийн тоо буурч байна. Хагас жилийн байплаар 42 иргэнд зөрчлийн тухай хууль, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ аваад байна. Энэ нь 2022 оны мөн үеийнхтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй юм.

“Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын сургалтын нэгдсэн хөтөлбөр”-ийн хүрээнд 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “ Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэлд хийх хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Хяналт шалгалтын газраас Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн нэмэлт, өөрчлөлтийн бүртгэлийн үйл ажиллагаанд 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 04 сарын 05-ны өдрийг дуусталх хугацаанд төлөвлөгөөт хяналт орсон байна.

Тус аймгийн улсын бүртгэлийн хэлтэст 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 03 сарын 21-ний өдрийг дуусталх хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хийсэн нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу үнэн зөв нэмэлт, өөрчлөлт хийсэн эсэх, холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт орж 18 алдаа зөрчил илэрснийг Улсын байцаагчийн 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн №40 тоот албан шаардлага ирүүлсэн. Тогтоосон хугацаанд зөрчлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэн албан шаардлагын хариуг хугацаанд нь хүргүүлж байна.

Мэдээллийн сангийн зөрчлийг арилгах зорилгоор 2021 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд төрөлтийн бүртгэлд алдаатай төлөвтэй эцэг эхийн мэдээлэл дутуу, бүртгэлийн дугаар ороогүй, бүртгэсэн он сар өдөр буруу орсон 8200 төрөлтийн бүртгэлийг мэдээлэл технологийн газраас жагсаалтаар гаргуулан авч зөрчил арилгах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Зөрчил арилгах ажлын хүрээнд 2021, 2022 онд нийт 2600 төрөлтийн бүртгэлийн зөрчлийг иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг хийлгэсэн. 2022 оны 11 сард улсын ахлах бүртгэгчид нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн эрхийг олгосноос хойш 134 бүртгэлд нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийсэн.

Хэлтсийн дарга, хяналтын байцаагч, ахлах бүртгэгч нарын бүрэлдэхүүн үүссэн алдаа зөрчлийг арилгах, цаашид зөрчил гаргахгүй байх талаар иргэний улсын бүртгэлийн газраас заавар зөвлөмж авч иргэний улсын ахлах бүртгэгчийг Иргэний улсын бүртгэлийн газарт нэг хоног ажиллуулж зөрчлийг арилгах ажлыг зохион байгууллаа.

Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, ахлах бүртгэгч Б. Сайхантуяа 2023 оны 04 сарын 20-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн газарт ажиллаж ахлах бүртгэгч Б. Отгоноос заавар зөвлөмж авч зөрчлийг газар дээр нь шийдвэрлэж ажилласан.

Овог нэр өөрчлөлтийн бүртгэл, үрчлэлтийн бүртгэл, эцэг тогтоолтын бүртгэл, үндсэн мэдээллийн санд овог өмнөх овог нэрийг оруулсан, дутуу шивэгдсэн эцгийн нэрийг оруулсан зэрэг 3 алдаанд хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны 04 сарын 25-ны өдрийн 2788 тоот дүгнэлтийг гаргаж хувийн хэрэгт цахимжуулж зөрчлийг бүрэн арилгаж ажиллалаа.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллах заалтын хүрээнд хэлтсийн даргын 2023 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн **A/09** тоот тушаалыг шинэчлэн батлуулж, улсын бүртгэлийн хэлтсийн ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, журмын хүрээнд

гаргасан 2023 оны дотоод үйл ажиллагаанд тавих хяналт болон ёс зүйн зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж байна.

Үүнд: Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн бүх албан хаагчдад цахим хэлбэрээр “байгууллагын стандарт, ёс зүйн” сэдэвт 8 төрлийн хичээл, сургалт, уулзалтын хуваарь гарган хэлтсийн даргаар батлууллаа. 2023оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Манлайлал” сэдвээр хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, 2023 оны 04 дүгээр сарын 12-нд Иргэний бүртгэлийн тасгийн дарга Б.Сайхантуяа “Хувь хүний хөгжлийн амжилтанд хүрэх алхам” сэдэвээр, 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр “Байгууллагын соёл” сэдэвээр хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн нар тус тус илтгэл мэдээлэл хүргэж ажиллалаа.

Хэлтсийн гэр бүлийн зөвлөлөөс албан хаагч нарын ажлын байранд эерэг харилцаа, хандлага нэмэгдүүлэх соёлыг төлөвшүүлэх, багаар ажиллах чадварыг идэвхижүүлэх зорилгын хүрээнд “Идэвхижүүлэх” 5-н өдрийн хөтөлбөр гаргаж даваагаас баасан хүртлэх ажлын 5 өдрийг “Азын өдөр”, “Талархах өдөр”, “Хайрлах өдөр”, “өгөх өдөр”, “Мэдэх өдөр” болгон үйл ажиллагаа зохион байгууллаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчээр шинээр томилогдсон Л.Мөнхсарнайд хэлтсийн ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг танилцуулж, ёс зүйн гэрээ байгууллаа.

Байгууллагын бүх албан өрөөнд “Төрийн албан хаагчийн тангараг”-ийг хэвлүүлж байршуулсан.

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Нийслэл, орон нутаг дахь хэлтэс, тасгийн хяналтын улсын байцаагч нарт "улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулах тухай хяналтын улсын байцаагчийн дүгнэлт" сэдэвт цахим сургалт зохион байгууллаа.

2. Сургалтаар УБЕГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/424 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн мэдээллийн нэдсэн санд түдгэлзүүлэх, цуцлах болон түздгэлзүүлсэн, цуцалсныг хүчингүй болгох тухай шийдвэрийн бүртгэл хөтлөх заавар”-ын танилцуулга, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 01 дүгээр сарын 28ны өдрийн 806 дугаар дүгнэлт, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1497, 1499, 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1543 дугаар дүгнэлт, Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны 1500 дугаар дүгнэлийн талаар тус тус сургалт зохион байгууллаа.

3. 2023 оны 03 сарын 29-нд улсын бүртгэгч нарт зөвлөмж чиглэл өгөх сургалт зохион байгууллаа.

4.Хэлсийн даргын 2023 оны 04 сарын 04-ны өдрийн төлөвлөгөөний дагуу

“Манлайлал”, “Хувь хүний хөгжлийн амжилтанд хүрэх алхам, цаг үеийн мэдээлэл”, “Байгууллагын соёл”, “Харилцаа, хандлага, бүтээмжид нөлөөлөх нь” сургалтуудыг 15 сумд, хэлтсийн албан хаагчдад цахим хэлбэрээр зохион байгууллаа.

5. 2023.04.10-ны өдөр Хууль зүйн дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзоригоор ахлуулсан багийн “Монгол улсын үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар танилцуулах хэлэлцүүлэгт Хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал,

хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Одонтунгалаг, Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, архивч Э.Мөнхсумъяа нар хамрагдлаа.

6. Цагдаагийн газраас зохион байгуулсан “Анзаар” мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сургалтад хэлтсийн 13 албан хаагч хамрагдлаа. Эрүүл мэндийн нийт 3 сургалтанд хамрагдсан. Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал, 2022 оны ХАСХОМ гаргах тухай

7. Төрийн албаны зөвлөлөөс онлайнаар зохион байгуулсан 4.7.10 сургалтад албан хаагчид бүрэн хамрагдаж мэдээлэл авч хэвшсэн. /Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага, Төрийн албан хаагч, Манлайлал, “Төрийн албаны шинэтгэл, сонгон шалгаруулалтын зохицуулалт”, “Үндсэн хуулийн үзэл баримтлал”, “Стрессийг зохицуулахад таны оролцоо”, “Цахим шилжилт”, “Бүтээмжээ нэмэгдүүлэх нь”, “Өсөлтийн сэтгэлгээ”, “Чингэс хаан Монголчуудын үнэт зүйл болох нь ба өнөө үе”/ сургалтуудад хэлтсийн албан хаагчид 25-27 хүн тухай бүр хамрагдлаа.

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтэс нь УБЕГ-ын Даргын тушаалаар үндсэн 28, гэрээт албан хаагч 2, нийт 30 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 ажилтан жирэмсэн амаржсаны чөлөөтэй Говь-Угтаал, Сайхан овоо суманд орон тоо дутуу ажиллаж байна. Тус хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хувийн аудитын компани 2023 оны 2 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан.

Тус хэлтэс 2023 оны 2-р улиралд нэмэлт санхүүжилтээр УБЕГ-ын Даргын 2023 оны 05-р сарын 22 өдрийн А/1003 тоот тушаалаар батлагдсан 2023 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардалд 5,750.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй байна.

Эхний хагас жилд байгууллагын 6 ахмадад 2023 оны сар шинийн баяраар тус бүр 130,0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, 2-р сард өндөр настан Г. Цогтсайханд амьдрах орчноо сайжруулахад нь зориулж 3,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн дэмжлэг нийт 3,780.0 мянган төгрөгийг Ахмадын сангаас зарцуулсан.

Хэлтсийн 2023 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг УБЕГ-ын СААХ-т Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу дараа сарын 15-ны дотор хуулийн хугацаанд хүргэгдэж нэгтгэгдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын программд 2022 оны жилийн эцсийн өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг 4-р сард оруулж хугацаанд нь тооцуулан ажилласан.

ТӨБЗГ-аас 2023 оны 6 сарын 7-8 ны өдрүүдэд тус аймагт ажиллаж, тус хэлтсийн 2022 оны Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэж сайн буюу А үнэлгээ өгсөн. Хагас жилийн бараа материалын тооллогыг Хэлтсийн Даргын 2023 оны 6-р сарын 8-ны А/14 тоот тушаалаар тооллогын комисс томилогдож, тооллого хийгдэж байна.


Батлагдсан төсвөөс 6-р сарын 01-ны байдлаар 268,100.4 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин хөлсний зардалд 186,847.6 мянга, унаа хоолны зардалд 10,478.0 мянга, НДШ-д 24,940.7 мянга, бичиг хэргийн зардалд 997.2 мянга, тээвэр шатахуунд 783.4 мянга, шуудан холбоонд 304.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 708.0 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн зардалд 710.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 608.0 мянга, мэдээлэл технологийн

үйлчилгээний хөлс 4,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 200,0 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 27,050.0 мянган төгрөг нийт 257,638.2 мянган төгрөг зарцуулж, 10,462.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй төсвийн гүйцэтгэл 96.1% байна.

Төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

хүснэгт.



УБЕГ-аас тус хэлтсийн 2023 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 70,000.0 мянган төгрөгөөр баталсан. 06-д сарын 01 өдрийн байдлаар орлогын төлөвлөгөөгөөр 29,166.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс, 34,252.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, жилийн орлогын төлөвлөгөөний биелэлт 117.4 хувьтай байна. Үүнээс 31,666.7 мянган төгрөгийг улсын төсөвт 100 хувь төвлөрүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон үйлчилгээний орлогын 1-р сараас 5-р сарын мэдээг тус бүр 5 удаа УБЕГ-т хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн 1-р сараас 5-р сарын тайланг сар бүр нийт 5 удаа, 2022 оны 4-р улирал, 2023 оны 1-р улирлын татварын тайланг цахимаар тоон гарын үсгээр баталгаажуулан улирал бүр гаргаж харьяа байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 01 өдөр хүртэлх хугацаанд нийт 68 мэдээлэлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 68 мэдээллийг хугацаа хоцролгүй үнэн зөв, бүрэн байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2023 оны 06 дугаар сарын 01-ны байдлаар байр ашиглалттай холбоотой байрны түрээсийн зардлын 1,223.5 мянган төгрөгийн өртэй ажиллаж байна. Санал, тооцооллыг УБЕГ-аар санхүүгийн хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

“EDOC” архив албан хэрэг хөтлөлтийн системийг нэвтрүүлэх тухай сургалтад хамрагдсанаар цахимаар бичиг солилцож бичиг хэргийн зардлыг хэмнэж ажиллаж байна. Албан хаагчдын нэвтрэлт жигдэрч хугацаа хэтэрсэн төлөвтэй албан бичиг байхгүй. Edoc програмд ирсэн явсан бичгийг тухай бүр нь бүртгэн оруулж, хугацаатай

бичгийн барагдуулалтад хяналт тавин ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй байна. 06 дугаар сарын 09-ний байдлаар 284 албан бичиг явуулсан байна. Тус хэлтсийн хэмжээнд 312 албан бичиг ирүүлснээс хариутай 161 албан бичиг байгаа бөгөөд бичгийн барагдуулалт 97,5%-тай хугацаа болоогүй 4 албан бичиг бүртгэгдсэн. Программ дээр нийт 312 албан бичиг ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 305, зөрчилтэй 1, судалж байгаа 6 албан бичгийн тайлан хэвлэгдсэн. Ирж байгаа хариутай бичгийн 70 хувь нь хууль хяналтын байгууллагаас ирүүлж байгаа бөгөөд 116 хариутай албан бичиг ирүүлснийг хугацаанд нь гарган хүргүүлсэн.

Иргэдээс бичгээр нийт 23, ажилтнаас 1 өргөдөл ирүүлсэн бөгөөд хугацаа болоогүй 1 өргөдөл байна. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 21 өргөдөл ирснээс Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 10, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр 11 иргэний мэдээллийг засварлаж оруулсан. Эдгээр өргөдлүүд нь эцэг эхийн мэдээлэл, төрөлтийн бүртгэл мэдээллийн санд ороогүй, ургийн овог зөрүүтэй, мөн овог нэрийн үсгийн зөрүүтэй, өөрийн хаягт хүүхдээ бүртгүүлэх, гэрлэлтийн бүртгэл мэдээллийн санд оруулах, регистрийн дугаар зөрүүтэй гэх мэт зөрчлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт холбогдох материалыг хүргүүлснээр мэдээллийн санд иргэдийн мэдээллийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр залруулан оруулж, хариуг иргэдэд утсаар болон биечлэн хүргүүлсэн. Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 2 өргөдөл ирүүлснийг хугацаанд нь хариуг өгч хаасан байна.Өргөдөл гомдлын барагдуулалт 95.8% хугацаа хоцроож шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.

А тушаал 14, Б тушаал 10 гарсан бөгөөд 2022 онд Хууль эрхзүйн хэлтсээс ирүүлсэн зөвлөмж, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбарын зөвлөмжийн дагуу хуулийн зүйл заалт болон архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан гаргасан. Эхний хагас жилийн байдлаар гаргасан тушаалыг ХЭЗХэлтэст хянуулахаар хүргүүлээд байна.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн гаргаж батлуулсан. Түр хадгалах 50 хадгаламжийн нэгж, байнга хадгалагдах 13 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалагдах 4 хадгаламжийн нэгж дотоод архивт хүлээн авсан байна.

АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2023 онд иргэний, гэр бүлийн бүртгэлийн (ИГББ) 8 төрлийн мэдээний ХААТР-Б маягтыг хүлээн авч хувийн хэрэгт галиглан шивж цахим санд оруулан, архивын санд байршуулан архивын эмх цэгцтэй байдлыг ханган ажилласан.

Мөн **613** ширхэг ХААТР маягтуудын /А/ талыг Үсгийн дарааллаар нь галиглан ангилан ялгаж нэг бүрчлэн шивж архивын ерөнхий газарт хүргүүлэн /Б/ тал нь архивт байрлагддаг.

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан дахин авсан ИУБ-31/Б/ маягтыг хувийн хэрэг тус бүрд нь байршуулдаг. ИУБ-31/А/ маягт **949** ширхэгийг иргэний баримтын төв архивд галиглан, шивж хавсралтын дагуу хүргүүлсэн. Мөн архивын материалын хавтаслалт, хадгалалт, хамгаалалт дотоод эмх цэгцийг сайжруулах ажлыг тогтмол хийж байна.

Сумдаас татан авсан журнал бүртгэлүүдээс төрөлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, эцэг тогтоолт, нас баралт, үрчлэлт, овог нэр өөрчлөлт гэх мэт журналын хуулбарыг олшруулан өгч иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг. Сумдын бүртгэгч нарт архивын журнал бүртгэлийг шүүж хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

2023 онд хадгалах хугацаа дууссан архивын устгах баримт журнал дэвтэрүүдийг ангилан ялгаж ББНШК-оор оруулан хурлын тэмдэглэлийн дагуу ерөнхий газарт хүргүүлэн гарсан шийдвэрийн дагуу устгалд оруулж хурлын тэмдэглэл илтгэх хуудсыг ерөнхий газарт хүргүүлсэн.

Дундговь аймгаас бусад аймаг нийслэлрүү шилжин явсан **149** иргэний хувийн хэргийг тухайн шилжин суурьшиж байгаа аймаг нийслэл рүү галиглан шивж хүргүүлсэн. Мөн бусад аймаг нийслэлээс шилжин ирсэн **78** иргэдийн хувийн хэргийг архивт хүлээн авч тус бүрээр нь галиглан ангилан ялгаж жагсаалтын дагуу тулган авч архивд уутлан цахимжуулж ХААТР маягтуудыг нэрсийн үсгийн дарааллаар нь шивж байршуулан ажиллаж байна.


Иргэний гэр бүлийн бүртгэлийн ИУБ маягтуудыг иргэний хувийн хэрэгт зохих журмын дагуу эхний улиралд архивлан байршуулсан. Үүнд :

- ХААТР -11 /Төрсний бүртгэл/ - 167
- ХААТР -12 /Үрчлэлт/ - 7
- ХААТР -13 /Овог нэр өөрчлөлт/ - 12
- ХААТР -14 /Эцэг тогтоолт/ - 8
- ХААТР -15 /Гэрлэлт/ -45
- ХААТР -16 /Гэрлэлт цуцлалт - 12
- ХААТР-18 /Нас баралт/- 105
- ЗӨБ /Засвар өөрчлөлтийн бүртгэл/ - 3

ЭХЭУБ-ийн үйлчилгээний архивын талаар

ЭХЭУБ-ийн архивын хувийн хэрэг нийт **18954** газар Үл хөдлөх нь **4435** ширхэг хувийн хэрэг хадаглагдаж хадгалалт хамгаалалтыг эмх цэгцтэй байлгах мөн хувийн хэргийн нэмэлт хуудсуудыг тэмдэглэгээ хөтлөн хаягжуулан архивын санд хадгалалт хамгаалалтын дүрэм журмын дагуу цэгцэлж хаягжуулан байршуулж байна. Архивч М.Отгонтуяа нь хагас жилд байрлуулсан хувийн хэргийн тоо 1256 ширхэг маягтуудыг хадгалалт хамгаалалтын дагуу цэгцэлж байрлуулсан байна. Бүртгэгч бүрийн дэвтэрт тулгалт хийж хөтөлгөөг давхар хийдэг.

Зураг: 1,2



УБЕГазраас ирсэн чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн тусгаарласан баримтуудыг нэг бүрчлэн тоолж стандартын дагуу 250 хуудсаар нэгж үүсгэн 155 нэгжийн 38750 ширхэг тусгаарласан хуудсыг ББНШК оор

оруулан устгалд оруулж хурлын тэмдэглэл илтгэх хуудсыг зургаар баталгаажуулан хүргүүлсэн.

Зураг: 3,4



Улсын бүртгэгч нараас хүлээн авч нэмэлт өөрчлөлт орж байгаа хувийн хэрэг бүрийг архивд хүлээн авч бичилт хийж хадгалалт хамгаалалтын хавтсанд байршуулан захиалгын хуудсаар олгож, тухайн өдөрт нь багтаан “архиваас түр олгох” ЭХЭУБ-ийн хувийн хэргийн бүртгэл /Маягт- А2/-д тэмдэглэл хөтлөн хүлээн авч, зориулалтын хавтаст хийн хувийн хэргийг тавиурт байрлуулж байна. Эд хөрөнгийн архивын хувийн хэргийг багтаамжийн дагуу цэгцэлж, нэмэлт өөрчлөлт орж буй хувийн хэргийг ангилан, хаягжуулж хайрцаглан байршуулсан.

Хуулийн этгээдийн архивын талаар :

Хуулийн этгээдийн Архивын тоо бүртгэл нь нийт **1406** хувийн хэргийг тухай бүр архивт байрлуулан нэмэлт өөрчлөлтөөр орж байгаа хувийн хэргийг архивлан байршуулдаг.

Ингэснээр хуулийн этгээдийн улсын бүртгэгч архиваас хувийн хэрэг өдөр тутам захиалан цахимжуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, архивын тэмдэглэл хөтлөн баримтыг буцаан авч байршуулах нөхцөл боломж бүрдсэн.

Шинээр өөрчлөлт орж буй хувийн хэрэгт тэмдэглэл хөтлөн архиваас гаргаж бүртгэгчийн гарын үсэг дугаарлалтаар нь хөтлөн архивлаж байршуулдаг.

2023 оны эхний хагас жилд хуулийн этгээдийн бүртгэгч нь нийт **139** ширхэг хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлт оруулан архивт байршуулсан байна. Хувийн хэргийг тухай бүр архиваас гарган нэмэлт өөрчлөлт орсон тухай тэмдэглэл хөтлөн хөдөлгөөнд оруулсан байна. Хуулийн этгээдийн шинээр орж ирсэн хувийн хэрэг 47 нэмэлт өөрчлөлт орж буй 92 хувийн хэргүүдийг тухай бүрт нь байршуулан ажиллаж байна.


Шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн **34** хувийн хэргийг цахим санд оруулан нэг бүрчлэн бүртгэл хийж архивд байршуулан хадгалагдаж байна. Хуулийн этгээдийн хүчингүй болсон **19** ширхэг тамга тэмдэг архивт хүлээн авсан.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

1.1. Хэлтсийн цахим мэдээллийн сан, нэгдсэн сүлжээ, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах чиглээр

Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмж, сүлжээний эвдрэл гэмтлийн засвар үйлчилгээ, программын шинэчлэлт хийх зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд:

- ✓ Иргэний бүртгэгчийн 2, Иргэний тасгийн дарга 1 компьютерт цахим гадаад паспортын программ суулгасан.
- ✓ Дэлгэрхангай, Дэрэн, Хулд, Луус сумдын бүртгэгчийн нөүтбүүк тоон гарын үсэг программ суулган 4g төхөөрөмж таниулсан.
- ✓ Эд хөрөнгийн тасгийн дарга Л.Мөнхсарнай scanner алдаа зассан ба нөүтбүүк windows **10** үйлдлийн систем болон шаардлагатай программуудыг суулгасан.
- ✓ Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн нөүтбүүк boot зассан.
- ✓ Эд хөрөнгийн бүртгэгч 2 компьютер windows **10** үйлдлийн систем суулгаж шаардлагатай программуудыг болон хурууны хээ уншигч таниулж суулгасан.
- ✓ Иргэний улсын бүртгэгч 2 компьютерт хурууны хээ уншигч суулгаад гацсан тул үйлдлийн системийг windows 7 болгож форматлав.
- ✓ Иргэний бүртгэгч Ш.Чулуунжаргалын принтерийн хорны чипийг сольсон.



1.2. Тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг ханган нууц үг, нэвтрэх нэрийг хагас жилд нэг удаа сольж тоног төхөөрөмжийн нууцлалыг хангаж ажиллах.

Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг ханган нууц үг, нэвтрэх нэрийг солих зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд:

- ✓ Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг ханган нууц үг, нэвтрэх нэрийг солих зэрэг ажлуудыг тухай бүрд нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.
- ✓ Хэлтсийн албан хаагчдыг ERP цаг бүртгэлийн системд бүртгэж өглөө орой ирцээ бүртгүүлэх нөхцөлөөр ханган ажиллалаа мөн эрхээ хаалгасан албан хаагчдын 5 эрхийг сэргээсэн, гар утасны ERP-д заасан алдаа тухай бүрд нь шийдвэрлэж нууц үгийг сольж ажилласан.
- ✓ Эд хөрөнгийн тасгийн дарга Л.Мөнхсарнайд EDOC эрх нээн албан мэйл солилцох боломжоор ханган ажиллалаа.


2023-05-01 - 2023-05-31

Бүх багана


Хайх утгаа оруулна уу


№	Нэгж	Албан тушаал	Албан хаагчийн нэр	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	Чөлөөц
				Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	
1	Уирдлага	Хэлтсийн дарга	Ж.Өлзийжаргал	И	И	И	Х	И			БД	И	И	Х	И		И	И	БД	И	И		БД	И	И	И	И		И	БД	И		00.0		
2	Хяналтын улсын б...	Хяналтын улсын байцаа...	Д.Нямсүрэн	Х	ГА	ГА	ГА	И			БД	И	То	То	Ч		То	И	И	И	БД		БД	И	Х	Х	БД		Х	БД	Х		16.0		
3	Иргэний улсын бүр...	Иргэний улсын бүртгэл...	Б.Сайхантуяа	БД	Х	И	И	БД			И	БД	То	То	И		То	То	То	То			То	То	И	И	И	БД		И	Х	БД		00.0	
4	Иргэний улсын бүр...	Улсын бүртгэл	Е.Батбаяр	И	Х	БД	БД	И			БД	БД	Х	То	И		Х	И	БД	БД	И		Х	И	И	И	Х		И	Х	БД	БД		00.0	
5	Иргэний улсын бүр...	Улсын бүртгэл	Ш.Чулуунжаргал	И	И	И	Ч	И			И	И	И	И	ГА		И	БД	То	То	То		И	И	И	Ч	Ч		И	И	И		00.0		
6	Эд хөрөнгийн эрхи...	Эд хөрөнгийн эрхийн Ул...	О.Ганцсүрэг	Э	Х	И	БД	БД			Х	БД	Х	И	И		Х	И	И	И			БД	И	Х	И	Х		И	БД	И		00.0		
7	Эд хөрөнгийн эрхи...	Эд хөрөнгийн эрхийн Ул...	Н.Уугантуяа	Х	Х	И	БД	И			И	И	То	Х	И		Х	И	И	И			И	И	И	И	Т		И	БД	БД		00.0		
8	Эд хөрөнгийн эрхи...	Эд хөрөнгийн эрхийн бү...	Л.Мөнхсарнай	И	И	И	И	И			И	И	И	И	И		То	То	То	То			То	И	И	И	И		БД	И	И		00.0		
9	Хуулийн этгээдийн ...	Хуулийн этгээдийн бүртг...	Б.Одонтуналал	Т	БД	Т	БД	БД			Х	И	То	БД	Х		И	И	И	И	Х		И	И	И	Х	БД	И		И	И	И		08.0	
10	Захиргаа аж. ахуй	Мэдээлэл технологийн а...	Г.Алтан-Од																																00.0
11	Захиргаа аж. ахуй	Мэдээлэл технологийн а...	Б.Жанцандорж	И	И	И	И	И			И	И	И	И	И		И	И	БД	И	И		БД	И	И	И	И		Ч	И	И		00.0		
12	Захиргаа аж. ахуй	Ажил нягтлан бодогч	Х.Гараа	Т	Х	Х	БД	Х			БД	Х	Ч	Ч	Ч		Ч	Ч	Х	БД	БД		Х	И	И	Х	БД		ГА	ГА	ГА		00.0		
13	Захиргаа аж. ахуй	Нэрвэ	Г.Нангом								БД	И	БД	Ч	БД																				00.0
14	Захиргаа аж. ахуй	Архивч	Э.Мөнхсумъяа	И	И	И	И	И			БД	И	БД	Ч	БД								И	И	И	И	И		И	И	И	И		00.0	
15	Захиргаа аж. ахуй	Архивч гэрээт	М.Отгонтуяа	Х	БД	Х	БД	БД			Х	И	И	БД	Ч		Х	Х	И	И			Х	Х	И	Ч	Ч		И	И	И		00.0		
16	Захиргаа аж. ахуй	Бичиг хэргийн эрхлэгч	Д.Наранцэцэг	А	А	А	А	А			А	А	А	А	А		Х	Х	И	И			Х	Х	И	И	И		И	И	И		90.0		
17	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Ш.Чулуун	Т	Т	Х	Х	И			БД	Х	БД	И	Х		И	И	Х	И			И	И	Х	И	И		И	И	И		00.0		
18	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	О.Улаануу	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		БД	И	И	И			Т	Т	Т	Т	Т		БД	Т	И		00.0		
19	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	М.Уранцэдэг	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т		00.0		
20	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Ж.Жамъяндорж	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т		00.0		
21	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Б.Баянжаргал	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	БД	И	И	И		И	И	И	Т	Т		Х	Х	Х		00.0		
22	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	С.Сарантуяа	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т		00.0		
23	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Ц.Гэрэлтуяа	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т	Т			Х	Х	БД	Х	И		Т	Т	Х		00.0		
24	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Ч.Гантсүс	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Х	И	И	И			И	Х	И	И	И		И	БД	И		00.0		
25	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Э.Ариунбилэг	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	БД		Т	Т	Т	Т			И	Э	Э	БД	Э		БД	Т	Х		00.0		
26	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Г.Долгормаа	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Т	Т	Т		00.0		
27	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Б.Санжармаа																																00.0
28	Сумдын бүртгэлч	Улсын бүртгэлч	Ж.Азава	Т	Т	Т	Т	Т			Т	Т	Т	Т	Т		Х	И	Х	Х	Т		И	И	Х	И	БД		Х	И	И		00.0		

1.3. Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер, принтер техник хэрэгслийн үзүүлэлтээр гаргаж мэдээллийн нэгдсэн сантай болох чиглэлээр Хэлтсийн 29 албан хаагчдын мэдээлэл тээгч техник, хэрэгслийн үзүүлэлтийг гарган, хувийн хэргийг хөтлөн, хавтаслалаа.



1.4. Хэлтсийн үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудас болон олон нийтийн хэрэгслээр сурталчлах, түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах чиглэлээр Хэлтсийн албан хаагчдын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудас болон олон нийтийн хэрэгслээр сурталчлах, түгээх нийт 37 мэдээг тус оны 5-р сард бэлдэж оруулсан байна. Мэдээ тус бүрийг цахим хуудсаар хууваалцсан.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

САЙНЦАГААН "МАЛЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН-2023"
2023-06-07

СУМЫН СУРГАЛТ,
Төрсний бүртгэлийг хэрхэн бүртгүүлэх вэ?
2023-05-22

Цахим илэрхийлэх тоон гарын үсэг
2023-06-05

Төрсний гүйцэтгэлийн 5-р сарын мэдээ, 2023 он

ВИДЕО МЭДЭЭ

Төрсний бүртгэлийг хэрхэн бүртгүүлэх вэ?
2023-05-22

Иргэн та байнга оршин сууга газрын хаягийн мэдээлээ дараах байдлаар шалгана уу
2023-02-06

ТОДРУУЛГА: Иргэний байнга оршин сууга газрын хаягийн таларх зарим асуудал...

Бусад мэдээлэл →

Бусад видео мэдээлэл →

1.5. Хэлтсийн вэб сайтын хөгжүүлэлт хийх чиглэлээр Мэдээллийн ил тод байдал шил ажиллагааны хүрээнд 63 шалгуураар хэлтсийн веб сайтад мэдээлэл бэлтгэн оруулж хөгжүүлэлт хийж ажиллалаа. Шилэн данс, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн үйлчилгээний үнэ хөлсний хэмжээг сайтаар дамжуулан харах боломжтой болсон. Иргэд QR код ашиглан хэлтсийн цаг үеийн болон нээлттэй ажлын байрны мэдээллийг харах боломжтой болж QR кодыг мэдээллийн самбар олон нийтийн сүлжээнд байршуулсан.

Дунговь аймгийн мэдээлэл хариуцагч байгуулгуудын нээлттэй мэдээллийг үнэлэх хуудас											
№	Бүлэг	Үүрэг/Засаг	Нээлттэй мэдээллийн байгууллагын нэр	Дунговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс							43
				1							
				МЭӨ	МОНЧ	НӨӨБ	МЭБ	МЭХ	МЭН	МЭД	
1	8.21	Хүн амын үйлчилгээ	15	10	5	30	30	30	30	30	43
2	8.21	Идэвхтэй ажлын үйлчилгээний үйлчилгээ	15	10	5	30	30	30	30	30	43
3	8.21	Идэвхтэй ажлын үйлчилгээний үйлчилгээ	15	10	5	30	30	30	30	30	43
4	8.21	Төрийн үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ	15	10	5	30	30	30	30	30	43
5	8.21	Төрийн үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ	15	10	5	30	30	30	30	30	43
6	8.22	МЭӨ	15	10	5	30	30	30	30	30	43
7	8.22	МОНЧ	15	10	5	30	30	30	30	30	43
8	8.22	НӨӨБ	15	10	5	30	30	30	30	30	43
9	8.22	МЭБ	15	10	5	30	30	30	30	30	43
10	8.22	МЭХ	15	10	5	30	30	30	30	30	43
	8.22	МЭН	15	10	5	30	30	30	30	30	43
	8.22	МЭД	15	10	5	30	30	30	30	30	43



1.6. Улсын бүртгэлийн үйлчилгээний сар бүрийн нэгтгэсэн тоон мэдээгээр инфографик мэдээлэл бэлтгэн сар бүрийн 28-ны дотор олон нийтэд хүргэх, вэбсайтад байршуулж ажилласан.

САР БҮРИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Эх сурвалжийг Мэдээллийн технологийн ажилтан Б.Жанчивдорж
Холбоо барих утас: 7059-2435


2023 оны 5-р сарын тоон мэдээ

© 2023-05-26


УНШИХ

1.7. Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч нарт өдөр тутмын шаардагдах хэрэглээний программын талаар сургалт хийж Хэлтсийн албан хаагчдыг чадваржуулах, албан хэрэгцээндээ Монгол бичиг нэвтрүүлэх зорилгоор программын сургалтыг цахим хэлбэрээр бэлтгэн хүргэсэн.

- ✓ Powtoon слайд бэлтгэх бэлэн загварын программ
- ✓ Canva бэлэн загвар ашиглах программ
- ✓ <http://trans.mglip.com/> монгол бичгээр хөрвүүлэгч программ



Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Иргэний 1 брошур 100 ширхэг, Эд хөрөнгийн 1 брошур бэлтгэн 50 ширхгийг хэвлэсэн, Хуулийн этгээдийн 2 бичлэг мэдээлэл бэлтгэн цахим хуудсанд нийтэлсэн. Иргэний үнэмлэх захиалах сунгуулахтай холбоотой 1 баннер монгол бичгээр бэлтгэн цахим хуудсанд нийтлэн ажиллалаа.






Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх

3.1 АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх; **Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Видео мэдээ, шторкийг цахим хуудсанд нийтэлж хамтран ажиллалаа.**

Үүнд:

- ✓ Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео блог брошур цахим хуудсанд байршуулсан.
- ✓ Авлигыг мэдээлэх нээлттэй утсыг веб сайттай байршуулсан.
- ✓ Авлигатай тэмцэх уриалгыг цахим хуудсаараа иргэдэд хүргэн ажиллаж байна.



3.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;
Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс”, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар тогтмол ажиллууллаа.





Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах

8.3 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангав.

Иргэдэд Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шил" ажиллагааны хүрээнд нээлттэй мэдээлэх Ил тод байдлын хэрэгжилтийг ханган ажиллаж 63 шалгуурын хүрээнд нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан ба хяналт шалгалт болон ЗДТГ-ийн IT Мөнгөн, мэргэжилтэн Оюунтунгалаг нараас зөвлөгөө авч сайжруулж веб сайтад хөгжүүлэлт хийн ажиллалаа. Мэдээллийн самбарт байрлах мэдээллийг тухай бүрд нь шинэчилж ажилсан.


Улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн дэлгэрэнгүйг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор QR код үүсгэн мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулсан.

Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах.

Сул орон тооны зарыг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор QR код үүсгэн мэдээллийн самбар, цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж ажиллалаа.



Хяналтын камер шаардлага хангахгүй болсон тул ашиглахгүй утас, залгуур, камер, дэлгэцийг салгаж шинээр IP камер суурилуулан хэлтсийн удирдлага үйлчилгээний танхимын үйл ажиллагааг гар утсаар хянах боломжийг бүрдүүллээ..



ТАЙЛАН НЭГТГЭСЭН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ